

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ХОРЬДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны есдүгээр сарын 28-ны 1 цаг 10 минутад эхэлж, 13 цаг 00 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 1 цаг 50 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Санхүү, эдийн засгийн газрын даргаар ажиллаж байсан Д.Батмагнайгаас гаргасан маргааныг хянан шийдвэрлэсэн Комиссын дүгнэлтийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “в”, Төрийн албаны зөвлөлийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 65 дугаар тушаалаар томилогдсон Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг үндэслэн:</p> <p>1. Д.Батмагнайг Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т “...тухайн төрийн байгууллага нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буугдсан, бүтцийн өөрчлөлт орж орон тоо хасагдсан бол түүнийг төрийн жинхэнэ албанаас чөлөөлнө” гэж, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-т “тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн”, 24.1.2-т “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн” гэж зааснаар үндэслэж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Санхүү, эдийн засгийн газар /хуучин нэрээр/-ын даргын албан тушаалаас чөлөөлсөн нь хууль зүйн үндэслэлгүй байх тул “Ажлаас</p>

		<p>чөлөөлөх тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Эрдэнийн 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн Б/119 дүгээр тушаалын Д.Батмагнайд холбогдох хэсгийг хүчингүй болгох</p> <p>2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
2	<p>Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан Г.Сайнбуянгаас гаргасан маргааныг хянан шийдвэрлэсэн Комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 3.4.6, Төрийн албаны зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 64 дүгээр тушаалаар томилогдсон Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг үндэслэн:</p> <p>1. Маргаан хянан шалгах комиссын “Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 18 дугаар тогтоолын хууль зүйн үндэслэлийг дахин хянан шалгуулахаар Салбар зөвлөлд хүргүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт”-ийг зүйтэй гэж үзэх</p> <p>2. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь Салбар зөвлөл /Ө.Баянмөнх/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны</p>

		зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	Увс аймгийн Өмнөговь сумын иргэн Д.Цэгмэдээс гаргасан маргааныг хянан шийдвэрлэсэн Комиссын дүгнэлтийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 3.4.6-д, Төрийн албаны зөвлөлийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 69 дүгээр тушаалаар томилогдсон Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг үндэслэн:</p> <p>1. Увс аймгийн Өмнөговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан мэргэшлийн шаардлагыг нэр бүхий 3 иргэн, мөн уг албан тушаалд тавигдсан туршлагын шаардлагыг нэр бүхий 1 иргэн хангахгүй байх тул уг албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаргуулалтыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж, “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэх, нэр дэвшүүлэх тухай” Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгох</p> <p>2. Увс аймгийн Өмнөговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сул орон тоог нөхөх нээлттэй сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар сарын 17.5-д заасны дагуу нийтэд 2017 оны 10 дугаар сарын 20-ны дотор зарлаж, сонгон шалгаруулалтыг хуулийн</p>

		<p>хүрээнд зохион байгуулахыг тус аймаг дахь Салбар зөвлөл /С.Батжаргал/-д үүрэг болгох</p> <p>3. Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг нарийн чанд баримталж, дахин ийм зөрчил гаргахгүй ажиллахыг Увс аймаг дахь Салбар зөвлөл /С.Батжаргал/-д үүгээр онцгойлон анхааруулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	<p>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр 2014-2016 онд ажиллаж байсан Э.Батболдыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, иргэн Эрдэнэбилэгийн Батболдын хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд томилогдон ажиллаж байсан Эрдэнэбилэгийн Батболдыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**